

## МОНГОЛЫН ТҮҮХЭН ДЭХ СОЛОНГОСЫН ИМИЖ

Ж. Баттөр

Монгол улсын их сургууль, Олон улсын харилцааны сургууль, ОУХ-ны тэнхим.  
[Batmoore@yahoo.com](mailto:Batmoore@yahoo.com)

**Өгүүллийн товч утга:** Түүхийн урт удаан хугацааны явцад аливаа улс орон, үндэстний талаарх ойлголт, мэдэгдэхүүн хил залгасан хийгээд ойр дөт оршдог ард түмний дунд нийтлэг байдлаар бүрэлдэн тогтдог. Үүнийг төрх, мэдлэг, үзэл гэж нэрлэж болно. Ялангуяа өнө эрт цагаас харилцаатай байсан нэг бүс нутгийн орнуудад бие биенийхээ талаар эерэг болоод сөрөг үзэл-төрх зайлшгүй тогтдог байна. Монголчуудын хувьд нэгэн бүс нутагт орших хятад, орос, манж, казах, япончууд болон бусад угсаатан, үндэстний талаар ямар үзэл-төрхтэй явж ирэв, тэр нь хэрхэн өөрчлөгдөж байв, мөн бусад угсаатан, үндэстнүүдэд монголчуудын талаар ямар үзэл-төрх бүрэлдэн тогтож байв гэдэг нь түүхч, угсаатны зүйчдэд судлууштай нэгэн сэдэв юм. Эл өгүүлэлд уг сэдвийн хүрээнд монголчуудын хувьд Солонгосын талаар ямар дүр төрхийг буй болгосон талаар түүхийн аргагүйн зарчмаар гарган харуулах зарим оролдлого хийв. Энэ судалгаанаас үзэхэд Монголын түүхийн явцад Солонгосын талаар ихээхэн эерэг, нааштай, элгэмсэг дүр төрх тогтсон болох нь харагдсан бөгөөд энэ нь ч хоёр орны өнөөгийн болоод цаашдын хамтын ажиллганы хөгжилд ач холбогдол бүхий хүчин зүйл болохыг харуулахыг зорив.

**Түлхүүр үг:** Монгол Солонгосын харилцаа, үзэл-төрх, Монголын түүхийн сурвалжууд, солонгосчуудын өргөдөл, захидал, Солонгосын дайн, хойд өмнөд Солонгос, Монголын сургамж, туршлага.

Бидэнд тодорхой мэдэгдэж байгаа үеэс л Монголын түүхэнд Солонгосын имиж (Image) байнга оршсоор ирсэн юм. Энд имиж гэдгийг мэдлэг, төсөөлөл, үзэл, хандлага гэсэн утгуудын ерөнхийлсөн хэлбэрээр хэрэглэв.<sup>1</sup> Харин англи хэлээр зарим үед энэ утгыг "Koreanness" хэмээн ихээхэн өвөрмөцөөр илэрхийлсэн ч байдаг. Солонгосын тухайд монголчууд өөрсдийнхөө эртний өвөг гэж үздэг нүүдэлчин угсаатны Сяньби, Нирун улсуудын үеэс мэддэг байсан гэдэг нь эдүгээ батлагдаад байгаа ч энд илүү тодорхой болгохын тулд түүнчлэн судлаач миний нимгэн мэдлэгийн улмаас 13-р зууны үеэс авч үзлээ.<sup>2</sup> Ерөөс миний бие Монголын бүх үеийн түүхэн дэх Солонгосын тухай имиж, төрх, мэдлэгийг илрүүлэн гаргах зорилго тавьсангүй, харин ойрхи үеийн түүхээс товч атугай түлхүү дурдахыг эрмэлзлээ.

XIII зуунаас өнөөг хүртэл тухайн цаг үе, гадаад дотоод орчин, харилцааны онцлог зэргээс шалтгаалаад Солонгос орны талаар ерөнхийдөө 5 янзын имиж төрх монголчуудад бүрэлдэж байжээ. Тэдгээр олон өнгө төрхөөс эл өгүүлэлд өгүүлэхийг чармайв. Харин Монголын тухай солонгосчуудын имиж, үзэл хэрхэн хувирч байв, монголчуудын талаар ямар үзэл, мэдлэгтэй байв гэдэг нь ч сонирхолтой асуудал бөгөөд бас л судлах ёстой сэдэв юм.

1. Эхний үе XIII-XIV зууны үетэй холбогдох болов уу гэж бодож байна. Энэ үед монголчууд гадагшаа дайн байлдаан хийж байсан тул ерөнхийдээ түүхийн ихээхэн баримт, эх сурвалжууд бидний үед хүрч ирсэн. Өгүүлэн буй үеийн төлөөлөгч болохуйц хамгийн оргил түүхэн бүтээл бол "Монголын нууц товчоо" билээ. "Монголын нууц товчоо" маш их баримтууд агуулж байдаг бүтээл бөгөөд бидний сонирхож буй сэдвээр ч зарим нэг баримт тээж буй. "МНТ"-ны 247-р зүйлд "Урьд Зөрчид, Солонгосыг эзлэхээр аяласан Жалайрдай хорчийн хойноос Есүдэр хорчийг явуулав. Түүнийг тэнд захирагч суутугай гэж зарлиг болгов" хэмээн тэмдэглэсэн байдаг.<sup>3</sup> Энд өгүүлж буй "Солонгос" гэдэг нь өнөөгийн Солонгосыг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, монголчууд XIII зууны үеэс л "Country of Rainbow" гэж нэрлэж байсан хэрэг. Тэгвэл яагаад ингэж нэрлэх болсон нь анхаарал татаж байна. Үүнийг наад зах нь гурван янзаар эрдэмтэд тайлбарласан байдаг. Үүнд

а) Монголын эзэнт гүрний үеийн монголчуудын их нүүдлийн зүүн хязгаар нь Бэгдү уул буюу Солонгосын хил хүрч байсан. Өвөл зуд турхан тохиолдох, бэлчээрийн даац багасах, дотоодын дайн самууны үеэр монгол угсаатны зарим овог аймгууд өнтэй дулаан газар өвөлжих, малын бэлчээр эрэлхийлэх үүднээс өргөн хэмжээний томоохон нүүдэл хийдэг байсан нь түүхэнд тэмдэглэн үлдээсэн байдаг. Тэр их нүүдлийн үеэр Бэгдү хэмээх тэрхүү сүрлэг өндөр уул нурууны хавиас ямагт солонго татдаг байсан тул уг нурууны өврөөр амьдрах улс болох Корей-г "Солонгын улс" гэж нэрлэсэн байх гэсэн таамаглал байдаг.

б) Солонгосын үндэсний хувцас "ханбог"-той холбосон тайлбар. Өөрөөр хэлбэл Солонгосын үндэсний хувцас тухайлбал бүсгүй хүний хувцасны өнгө ихээхэн баялаг үзэсгэлэнтэй байснаас ийнхүү нэрлэсэн гэж үзсэн эрдэмтэд буй. Ялангуяа солонгосын хүүхдийн хувцасны ханцуй нь өнгө өнгөөр хослуулсан байдаг нь чухамдаа солонгос санаа авсан болов уу гэмээр байдаг.

в) Аймгийн нэр. Тэр үед Монголын зүүн этгээдээр солон, солонгод зэрэг аймгууд байсан. Тэдгээр аймгуудтай ойролцоо болох тул тийн нэрлэсэн ч байж магадгүй гэсэн таамаглал дэвшүүлж болохоор.

1.2. Энэ үед холбогдох зарим домгууд байна. Тэдгээрт гардаг нэг санаа бол Чингис хааны бага гүнж Хулан, зарим домогт Хулан саран гүнжийн тухай өгүүлдэг. Үүнд, "Аргасун хуурчийн домог", "Хулан саран гүнжийн домог", буриадуудын дунд дэлгэрсэн "Бөртгөлжин хатны домог" зэрэг домгуудыг нэрлэж болно. Эдгээр домогт өгүүлсэн нэг санаа бол Чингис хааны гүнж Хулан (Хулан Саран гүнж) Солонгосын хааны охин байсан тухай юм. Ер нь зарим түүхчдийн бичснээр Монголын эзэнт гүрний үед олон тооны залуу бүсгүйчүүд Монголд бэр буун одож байсантай холбон бодвол энэ нь жир нэг домог биш ч байж болох юм.<sup>3</sup>

1.3. Монголын уран зохиолын дээж зуун билиг болон "Лу. Алтан товч"-ид "Чингисийн есөн өнгөт улс"-ын тухай өгүүлдэг. Тэнд Солонгосыг хөх өнгө лугээ холбосон байдаг.<sup>4</sup> Монголчуудын бэлгэдэлзүйн уламжлалт сэтгэлгээгээр хөх өнгө бол хамгийн их эрхэмлэдэг өнгийн нэг байсан. Тухайлбал монголчууд "хөх тэнгэр" хэмээн өнө мөнх, үнэнч хувирашгүй байдлыг бэлгэддэг билээ. Тиймээс Солонгосыг ийнхүү "хөх өнгөт улс" гэсэн нь сонирхолтой юм. Түүнчлэн "Чингис хааны их өчиг"-т Солонгосыг

"...Ургах нарны язгуурт

Үнэгэн мөрөн нутагт

Унасан цасан идэшт

Булган хэрмэн дээлт

Цагаан Солонгос улс мину" гэж цагаан өнгөөр нэрлэжээ.

1.4. XIX зууны монголын нэрт зохиолч Инжинаашийн "Хөх судар" түүхэн романд бичсэнээр Чингис хааны есөн өрлөгийн нэг солонгос хүн байсан гэж гарч буй. Чингис хаан чин үнэнч бөгөөд дайчин хэн ч байсан өөртөө татан авч их үүрэг хариуцлага, итгэл хүлээлгэдэг байсныг бид мэднэ.

1.5. "Корё-са"-д гарч буй монгол Солонгосын харилцааны бичгүүдээс үзвэл монголчууд солонгосоос цаас, бэх, торго, бийр гэхчилэн соёлын бараа авч байсан тухай тэмдэглэжээ. Энэ бол монголчууд Солонгостой соёлын өргөн харилцаатай байсан гэж хэлэхэд хүргэж байгаа юм.<sup>5</sup>

1.6. 1218 онд Монгол Солонгос хоёр улс "Ахан дүүгийн гэрээ" байгуулсан юм.

1.7. Монгол угсааны хаадын гүнж нар Солонгосын хаадтай гэр бүл болж төрийн ураг барилдаж байсан. Түүхэнд тэмдэглэсэнээр Солонгосын хэд хэдэн хаан Монгол угсааны хаадын гүнж нартай урагласан байдаг.<sup>6</sup>

Дээрх баримт жишээнүүдийг цаашид үргэлжлүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай ч ерөнхийд нь дүгнэвэл 13-14-р зууны монголчуудын Солонгосын талаархи имиж буюу монголчуудад төрж байсан сэтгэгдэл нь эрхэм, чухал, гэрэл гэгээтэй гэсэн шинжтэй байжээ гэж хэлж болохоор байна. Энэ имиж буй болоход Солонгосын дайнч бус, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого ч нөлөөлсөн болов уу. Харин Юань улс мөхснөөр Солонгос дахь Монголын нөлөө ихээхэн хумигджээ. Ялангуяа 17-р зууны дунд үеэс манж Чин улс ихээхэн хүчирхэгжихэд Монгол, Солонгосын аль алин нь Чин улсын вассал улс болсон нь хоёр орны харилцаанд хаалт саад болсон. Ийм байдал XX зуун хүртэл үргэлжилсэн билээ.

2. XX зууны эхээр 1911 онд Монгол улс Чин улсын харъяанаас гарч тусгаар тогтнолоо зарласан. Харин 1910 онд Солонгос Японы колони болсон билээ. Энэ үеэс монголд Солонгосыг сонирхох нь ихэссэн байдаг.

2.1. Эдүгээ Монголын Үндэсний төв номын санд 1910-аад үед орчуулсан гэж үзэж буй хоёр бэсрэг ном хадгалагдаж байна. Гэхдээ тус тусдаа бус нэг үргэлжилсэн ном юм. Эхний ном нь "Хан улсын мөхсөн түүх" дараагийн ном нь "Улс мөхсний нулимсан" гэсэн нэртэй. Нийт 50 нүүр, хүн газар нутаг, хот орны нэрсийг хятад дуудлагын дагуу, манж үсгээр галиглан бичжээ. Эдгээр номын гол агуулга нь Япон улс Солонгосыг ямар арга хэрэглэн өөрийн колони болгосон, гадаад дотоод нөхцлийг яаж ашигласан, Солонгосын эрх баригчдын зүгээс гаргасан алдаа, эх орноосоо урвасан нь ямар уршиг тарьсан, колони болсноороо Солонгос орон ямар хэцүү хүнд байдалд орж байгаа, яавал Японы колониос ангижирч тусгаар тогтнолоо олж эх орноо хүчирхэгжүүлэн мандуулах тухай гээд маш олон талыг хамарсан бүтээл юм.

Эдгээр номд Японы зүгээс хүчээр тулган байгуулсан улс төрийн гэрээ бичгүүдийг бүрэн орчуулан тайлбарын хамт багтаажээ. Уг бүтээлийг тухайн үед монголчуудад Японы зүгээс учруулж мэдэх аюул заналыг мэдүүлэх, сургамж авах, дүн шинжилгээ хийх зэрэг зорилгоор орчуулсан болов уу гэж үзэж байна.<sup>7</sup>

2.2. Өгүүлэн буй үед Монголд гарч байсан сонин хэвлэлүүдэд Солонгосын талаарх мэдээ сурвалжлага байнга гарч байсан агаад гол агуулга нь Японы бодлогыг эрс шүүмжилсэн, Солонгосын ард түмний дарлагдал талхигдлыг өрөвдөн хөөрхийлсэн үгээр бичсэн байна. 30-40-өөд онуудад гарсан сурах бичгүүдэд Солонгосын тухай ихээхэн баримт оруулсан байдаг нь сонирхолтой.<sup>8</sup>

2.3. Монголын ГХЯ-нд хадгалагдаж буй нэгэн өргөдөл байна. Уг өргөдөлд Солонгосын 3000 иргэн Японы дарлалаас дайжин эх нутгаасаа гарч, Оросод оршин сууж байгаад 1920-иод онд Орост өлсгөлөн нэрвэх үед Монголын Засгийн газарт хандан, дагаар орж Монгол улсын харъяат болж газар тариалан эрхлэхийг хүссэн агуулгатай юм. Тухайн үеийн олон улсын харилцаа нэн төвөгтэй түгшүүртэй болж байсан түүнчлэн жижиг Монгол улс ЗХУ-д буй хүмүүсийг өөртөө оруулан орогноулах нь аюултай байсан тул Монголын Засгийн газар татгалзсан хариу өгсөн байдаг.<sup>9</sup>

2.4. Мөн үед Орост байсан солонгос иргэдэд Монголын Засгийн газраас нэлээд хэмжээний мөнгөн тусламж олгохоор шийдвэр гаргаж Москва дахь Монголын ЭСЯ-наас солонгосчуудыг төлөөлөх байгууллагыг эрж хайж байсан баримтууд их үлджээ. Мөн солонгос хүүхдүүдэд мөнгөн тусламж олгохоор тогтсон шийдвэрүүд ч хадгалагдан иржээ.<sup>10</sup>

2.5. Монголын иргэн болох өргөдлүүд, Монгол дахь солонгосчуудтай холбоо бүхий оршин суух визийн зөрчлүүдийн тухай өргөдлүүд нэлээд хадгалагдан үлджээ. Монголын холбогдох яам тамгын газруудаас тэдгээр визний зөрчилтэй холбогдох хэргүүд, орон нутгаасаа дайжсан солонгосчуудад хүмүүнлэгийн үзлээр хандан нааштайгаар шийдвэрлэж байлаа.<sup>11</sup> Тэдгээр өргөдөл, хүсэлтүүдийг уншихад өдгөөгийн Өмнөд Солонгост хууль ёсоор

болоод хууль бусаар ажиллаж байгаа монголчуудад тохиолдож байгаа оршин сух визтэй холбоотой зүйл асуудлуудтай агаар нэгэн байгаа нь түүх давтагддагийг тэгэхдээ байраа сольсон байдлаар давтагддагийг харуулах мэт.

Дээрх жишээнээс үзвэл ХХ зууны эхэн үеэс 1930-аад оны сүүлч буюу дэлхийн II дайн хүртэл Монголын ард түмэн, Засгийн газраас солонгосчуудыг Японы колони болж, зовж шаналж буйд ихээхэн өрөвдөн хайрлаж, өмөөрч байсан нь тодорхой байдаг. Солонгостой шууд харилцаа тогтоох боломжгүй байсан тул, Орост байсан иргэдэд нь туслахаар чармайж байжээ. Харин дэлхийн II дайн дэгдснээр нэг хэсэг харилцаа тасарсан юм.

3. Дэлхийн II дайны дараа Солонгос орон Японы колончлолоос чөлөөлөгдсөн ч хэдийгээр нэг үндэстэн боловч олон улсын харилцааны хэт нөлөөллөөс болж эсрэг тэсрэг тогтолцоо бүхий хоёр орон болон хуваагдсан билээ. Монгол улс ч тухайн үеийн хоёр туйлт тогтолцооны уршгаар зөвхөн хойд Солонгостой албан ёсоор дипломат харилцаа тогтоохоос өөр аргагүй болж, нэг чиглэлээр хөгжиж ирсэн. Гэхдээ хоёр орны харилцааны агуулга зөвхөн коммунист сэтгэлгээнээс цааш гараагүй гэж үзэх аргагүй юм. Өөрөөр хэлбэл ихээхэн элгэмсэг харилцаа байсан гэж хэлж болно.

### 3.1. Солонгосын дайны жилүүдийн тусламж

1950 оны 6 сарын 25-нд Солонгосын дайн дэгдсэн билээ. Энэ үед монголчууд зөвхөн ганц талтай нь харилцаатай байсан тул авч байсан мэдээлэл нь Өмнөд Солонгосын И Сын Маний тоглоомын дэглэм (Сөүлийн олимпийг хүртэл Өмнөд Солонгосын Засгийн газрыг ийнхүү нэрлэж байсан.) АНУ-ын дэмжлэгтэйгээр хойд Солонгос руу халдснаар энэ дайн эхэллээ гэж нийтээрээ үзэж тийнхүү тайлбарласаар ирсэн. Тухайн үед Монголтой хөрш ЗХУ дэлхийн II дайнд ихээхэн хохирол гамшигт нэрвэгдэн байж дайнд ялалт байгуулаад байсан ба Монгол зэвсэгт хүчин ч мөн чөлөөлөх дайнд оролцож Хятадыг чөлөөлөлцсөн байсан. Өөрөөр хэлбэл монголчууд дайны аюулыг туулсан ард түмэн байв. Солонгосын дайн эхэлмэгц монголчууд АНУ-г маш ихэд буруушааж байлаа. Тиймд хойд Солонгосыг дайнд өртсөн улс гэж үзэн эхнээсээ солонгосын ард түмэнтэй эв санааны нэгдэлтэй гэдгээ удаа дараа мэдэгдэж байв.

Ингээд монгол орон даяар солонгосын ард түмэнд туслах хөдөлгөөн өрнөж олон түмний сайн дурын хандив, Монголын Засгийн газрын нөөц хөрөнгөөр хүмүүнлэгийн асар том тусламж үзүүлсэн юм. Үүнд: 226 мянга гаруй толгой мал, 5 мянган тонн улаан буудай, 7.3 мянган тонн мах болон хүнсний бүтээгдэхүүн, 120 мянга гаруй ширхэг төрөл бүрийн бэлэн хувцас (дийлэнх нь үстэй хүрэм гэх мэт дулаан хувцас) бэлэглэсэн бөгөөд 30 гаруй оюутныг өөрийн их, дээд сургуульд үнэ төлбөргүй сургасан байна.<sup>12</sup>

### 3.2. Өнчин хүүхдүүд

Солонгосын дайнаар хохирсон солонгосчуудад Монголын ард түмнээс үзүүлсэн хүмүүнлэгийн тусламжийн нэг хэсэг нь дайнд эцэг эхээсээ хагацсан өнчин хүүхдүүдийг Монголд авчран хооллож, ундалж, халамжилж, сургалт боловсролоор дэмжсэн явдал юм.

1952 онд Монгол улс хойд Солонгосоос дайнд өнчирсэн нийт 197 хүүхэд хүлээн авч 1959 оныг хүртэл буюу 7 жил эх орондоо байлгасан. Тэд улмаар монголын ард түмэнд ихээхэн элэгтэй болж сайхан сэтгэлээр хандах болсон байдаг.<sup>13</sup>

### 3.3 Дайны дараах бүтээн байгуулалт

Түүнчлэн Солонгосын дайны дараа эдийн засгаа сэргээн босгож, өлсгөлөнгөөс салахад нь мөн багагүй хэмжээний тусдламж олгосон. Тухайлбал 1955 онд 20 гаруй мянган толгой мал, нэлээд их хэмжээний мах, цөцгийн тосыг буцалтгүй тусламж болгон бэлэглэсэн бол 1956 онд 12 мянган толгой мал, 5000 гаруй тонн үр тариаг олгосон. Энэ бол зөвхөн хоёрхон жилийн тусламжийг жишээ болгон өгүүлж байна.<sup>14</sup>

Хойд Солонгост тусламж олгодог уламжлал бүр 90-ээд онд ч үргэлжилсээр байсныг дурдах хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд хэдийгээр монголын нийгэм, эдийн засаг шилжилтийн үеэ туулж яваа ч Монголоос хойд Солонгост мах, хүнсний спирт, ямаа зэрэг голлон хүнсний чиглэлийн хүмүүнлэгийн тусламж үзүүлээд байна.

Дээрх харилцаанаас ажиглавал монголчуудаас Солонгос хэмээх түүхэн нэгэн үндэстний нэг хэсэг болох хойд Солонгост чин сэтгэлээсээ зарим үед өөрсдийн боломжоос бараг хэтэрсэн хэмжээгээр туслаж ирснийг харж болох бөгөөд харин манай орны зүгээс цэргийн стратегийн ямар нэг ашиг хонжоо эрж байгаагүй билээ.

4. 1990 онд Монгол улс БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоов. 1990 онд ЗХУ задарч алга болсноор Монгол улс бүрэн утгаараа тусгаар тогтнолоо бэхжүүлж чадав. Монголд байрлаж байсан Зөвлөлтийн цэргүүд бүрэн гарч, Монголын шинэ үндсэн хууль батлагдав. Иймээс монгол улс гадаад бодлогоо ч Кремлийн заавраар явуулахаа больж бие даан шийддэг болсон юм. Энэхүү бие даасан гадаад бодлогын хамгийн том ололтын нэг нь 1990 оны 3 сарын 26-нд Монгол улс Азийн хуучин коммунист орнуудаас хамгийн түрүүнд, хөрш хоёр их гүрэн ОХУ, БНХАУ-аас өмнө БНСУ-тай албан ёсны дипломат харилцаа тогтоосон явдал билээ. Ийнхүү харилцааны олон зуун жилийн уламжлалтай, ямагт хүнлэг дотно харилцаатай явж ирсэн Солонгос үндэстэнтэй бүрэн харилцаагаа сэргээсэн байна.

#### 4.1. Сөүлын олимп ба бахархал

Өмнөд Солонгостой харилцаагаа хөгжүүлэхэд түлхэц өгч, коммунист орнууд түүний дотор монгол хүмүүсийн анхаарлыг татсан үйл явдал бол Сөүлийн олимп байсан агаад уг олимпын үеэр монголчууд өмнөд Солонгос хэмээх нэгэн цэцэглэн хөгжсөн орон байна гэдгийг олж нээсэн. Улмаар зөв хөгжиж чадвал монголчууд орчин үеийн хөгжингүй орон болж чадах юм байна гэсэн итгэл төрсөн гэж хэлж болно.

#### 4.2. Хөгжлийн туршлага

1990-ээд онд коммунист эдийн засгийн тогтолцоо нуран унаж нийгэмд тогтворгүй байдал, түгшүүр, маргаашдаа үл итгэх явдал газар авч, архидалт, ажилгүйдэл олныг хамарсан шинжтэй болсон билээ. Энэ үед эдийн засаг нийгмээ ямар чиг баримжаагаар хөгжүүлэх вэ, ямар арга зам, бодлого хэрэгжүүлэх вэ гэсэн асуудал тулгамдсан асуудал болсон бөгөөд энэ талаар ихээхэн туршлага хуримтлуулсан орон бол Өмнөд Солонгос юм байна гэж Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр ихээхэн шуугих болсон юм. Гэвч Өмнөд Солонгосын хөгжлийн загварыг ул суурьтай судласан үндэсний эрдэмтэн судлаач ч байсангүй, нөгөө талаар Монголд АНУ, Японы нөлөө ихээхэн газар авснаар тэдгээр орны санхүүжилтээр хийгдсэн судалгааны төслүүдээр дамжуулан АНУ маягийн чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоог дээдлэн шүтэх болсон. Тиймээс АНУ-ын эдийн засагч Милтон Фридманы болон Хаек нарын эдийн засгийн либерал чиг хандлагатай номуудыг ихээр орчуулж танилцуулах болсон. Эдгээр шалтгааны улмаас өмнөд Солонгосын хөгжлийн загварыг анхаарах сөхөөгүй байсаар сүүлийн үед ядуурал 40 орчим хувьтай

болж, ажилгүйдэл нийгмийн хурц асуудал болон тавигдаж, гадаадын хөрөнгө оруулалт уул уурхайн салбараас бусад салбарт төдийлөн өсөхөө болино, томоохон албан тушаалтнуудтай холбоотой авилгалын хэрэг нэмэгдэх хандлагатай болсон ч шүүхээр шийдвэрлэх механизм нийгэмд адил тэгш үйлчлэхгүй байгаа зэргээс үүдэн Өрнөдийн хөгжлийн загварт олон хүн найдахаа больж эхэлсэн билээ. Тэгээд эхлэхээр эргээд Солонгосын хөгжлийн загварыг нийгэмд сонирхох болж байна.

#### 4.3 Худалдаа, драм, ажилчин, солонгос хэл

Өмнөд Солонгостой хөгжүүлж буй харилцааг ихээхэн олон талтай баялаг гэж хэлж болно. Цөөхөн хэдэн жишээ дурдъя. Монголын телевизүүд "Ханрю" буюу "Солонгос цутгалан" нэн хүчтэй газар авч, түүнээс үүдээд монголчууд цуврал олон ангит драмаар амьсгалж байна гэж хэлж болно. Өдөр бүр Монголын аль нэг сувгаар зайлшгүй наад зах нь нэг солонгос драм гардаг. Үүнтэй холбоотойгоор солонгос хувцас, үс засалт, гоо сайхан, хоол, машин, ерөөний интерьер дэлгэрч байна. Мөн солонгос хэлийг хүмүүс ихээр сонирхох болсон. Солонгосын түүх, зан заншил, ард түмнийх нь амьдрал ахуйг ч их анзаарах болжээ.

Солонгосыг ажиллаж, амьдрахад нэн тааламжтай орон гэж үзэн очих гэсэн хандлага давамгайлсан. Харин визний асуудал төвөгтэй байдгаас аялал жуулчлалаар очих, сурахад амаргүй болсон. Түүнчлэн боловсролын салбарт солонгос хэлийг сурах, мэргэжил эзэмших гэсэн залуучуудын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Өнөөдрийн байдлаар монголд нийт 11 их дээд сургуульд 57 багш солонгос хэлийг зааж байна.<sup>15</sup> Одоогийн байдлаар улсын хэмжээгээр солонгос хэлний багш болон орчуулагч, судлаач мэргэжлээр 800 гаруй хүнийг төгсгөөд байгаа бөгөөд нийт 600 оюутан (мэргэжлийн бус ангид суралцаж буй оюутнуудыг оруулбал 1500 хүн) дээрх их дээд сургуулиудад суралцаж байгаагаараа 10.000 хүн амд ногдох солонгос хэлтэй хүний тоогоор Азид дээгүүр байранд орж байна.<sup>16</sup>

БНСУ-д эдүгээ 20 гаруй мянган монгол иргэн дийлэнх нь хууль ёсоор ажиллаж байгаа бөгөөд тэдний ар гэр рүүгээ гуйвуулж буй мөнгө өрхийн болоод улсын эдийн засагт томоохон үүрэг гүйцэтгэж байна. Статистик тооцоогоор Монголд нийт 596.400 гэр бүл байдаг гэдгээс үзвэл айл өрхийн амьжиргаанд хичнээн их ач тустайг тоочоод байх шаардлагагүй болно.<sup>17</sup> Мөн монгол эмэгтэйчүүд солонгос эрэгтэйчүүдтэй гэр бүл болох явдал сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай болоод байна. Албан ёсоор солонгос хүнтэй гэр бүл болсон. Өөрөөр хэлбэл, Монголын иргэний бүртгэл мэдээллийн төвд албан ёсоор бүртгүүлээд гарсан олон зуун монгол бүсгүй байна.

#### 5. Солонгосын нэгдэлд хамгийн их ач холбогдол өгч буй орон

Монгол орон бол ЗХА-ийн бүс нутагт буй их гүрнүүдийн дэргэд газар нутгийн хэмжээ, байгалийн баялагийг эс тооцвол хамгийн бага, бас хамгийн буурай орон юм. Тийм учраас ямар ч орны нөлөөнд орчих вий гэсэн айдас монголчуудын дунд түгээмэл байдаг агаад хамгийн санааг нь зовоодог орон бол хятад юм. Монголчууд Хятадын эдийн засгийн түргэн өсөлт, зэвсэгт хүчнээ орчин болгож буй үйл явц, бүс нутагт өдрөөс өдөрт нэмэгдэж буй жин нөлөө, Монголын голлох түүхий эд буюу ноос, ноолуур, арьс шир, зарим эрдэс түүхий эдийн салбарт тогтоогоод буй давуу байдлууд нь олон монгол хүнийг хятадын нөлөөнд орчих вий гэсэн айдас, түгшүүрт хүргэж байгаа билээ. Тиймээс солонгосчуудыг түүхийн үүднээс ч тэр эдүгээ ч тэр чухал нэгэн тэнцвэржүүлэгч орон гэж үздэг юм.

Түүнчлэн манай улс Солонгосын хойгийг тойрсон их гүрнүүдээс эрс өөр нь уг хойгт хүчний тэнцвэр, уламжлалт геополитикийн ямарваа нэг ашиг сонирхолгүй билээ. Тиймд хоёр Солонгос нэгдсэн тохиолдолд эдийн засгийн болон интегралчлал, тээвэр, хөрөнгө оруулалтын асар их ашигтай нөхцөлүүд Монголын өмнө нээгдэж байгаа болно.<sup>18</sup>

## 5.2. Умард Солонгосын дүрвэгсдийн асуудал

Эдүгээ дэлхий нийтийн анхаарлыг байнга татаж буй бүс нутгийн хурцадмал нэгэн асуудал бол хойд солонгосын дүрвэгсдийн асуудал агаад өөрийн хоёр хөрш ялангуяа БНХАУ-аас ялгаатай нь Монгол улс хүмүүнлэгийн үүднээс хандаж, хил дээрээс буцаалгүйгээр тэднийг нутагтаа байрлуулсан, хооллож ундлаад хүссэн гуравдагч орон руу нь саад тавилгүй гаргаж байна.

Монгол улсын ерөнхийлөгч Н.Багабанди хойд солонгост айлчилсан айлчлалыхаа үеэр тэдний дүрвэгсдэд газар олгон газар тариалан эрхлэхэд нь дэмжинэ гэснээс гадна Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлж эхлээд буй "40.000 айлын орон сууц" хөтөлбөр, Монгол улсыг зүүнээс баруун тийш бүрэн холбосон авто замын "Мянганы зам" зэрэг барилга, замын томоохон бүтээн байгуулалтын салбарт хойд Солонгосын ажилчдыг оролцуулах сонирхлоо илэрхийлж энэ талаар хойд Солонгосын холбогдох сайдууд удаа дараа айлчлал хийж байна.

Мөн хойд солонгосын ажилчид монголд ажиллаж амьдрахад сар бүрийн визний бүртгэлийн хураамжаас чөлөөлөх талаар хоёр талын холбогдох байгууллагууд ярилцаж байна.

## 5.3 Цөмийн асуудалд бидэнд туршлага бий

Дэлхий нийтийн хэмжээнд үүсээд буй хойд солонгосоос гаралтай нэг том аюул бол хойд солонгосын цөмийн хөтөлбөр билээ. Энэ талаар эдүгээ ихээхэн ярьж бичиж байна. 6 талт хэлэлцээрийн гол хэлэлцэх гээд буй асуудал ч хойд солонгосын цөмийн хөтөлбөр. Харин гадаадын орнууд түүний дотор 6 талт хэлэлцээрт оролцож буй орнуудын төдийлөн анхаарлаа хандуулахгүй байгаа нэг зүйл бол Монгол улс цөмийн зэвсэггүй статустай болсон туршлага юм.<sup>19</sup>

5.4. Бидний алдаа оноо хойд солонгосчуудад том сургамж, үнэтэй туршлага гардаг.

Монгол улс 1990 оноос хойш зах зээлийн эдийн засгийн замаар тууштай замнаж байна. Сүүлийн 15 жилийн хугацаанд манайд хэрэгжүүлсэн хамгийн том ажлууд бол:

1. Хүний эрхийг үндсэн хуулиар баталгаажуулж, ардчиллын үнэт зүйлүүдийг нийгэмд хэвшүүлж эхэлсэн.
2. Өмчийн эрхийг баталгаажуулсан.
3. Хуучин улсын буюу төрийн өмчинд байсан аж ахуйн нэгжүүдийг тууштай хувьчлаар ойрын хугацаанд бүрэн хувьчилж дуусах төлөвтэй байна.
4. Иргэдэд орон сууц, мал, газрыг үнэ төлбөргүй хувьчилсан.
5. Гадаад бодлогодоо улс төрийн ямарваа нэг онол сургаалыг бус, эдийн засгийн хөгжлөө дэмжих, хамтын ажиллгааг өргөжүүлэх чиглэлээр прагматик бодлогод суурилсан зарчмыг баримтлах болсон.
6. Нээлтэй нийгэм буй болгоход анхаарах болсон.

Гэхдээ хэдийгээр товчхон өгүүлбэрээр илэрхийлсэн эдгээр үйл ажиллагаануудын цаана нийгмийн асар том гүнзгий өөрчлөлтүүд гарсан билээ. Хувь хүн бүрийн ахуй амьдралд эерэг сөрөг бүх хэлбэрээр нөлөөлсөн эдгээр хувьсал, хувьсгалууд нь манайхтай ижил төстэй өөрчлөлт хийх бүх орон, түүний дотор хойд Солонгост чухамдаа алтан сургамж болох юм. Нэг үгээр монгол

улсын, монгол хүн бүрийн хамтран туурвиж буй энэхүү сурах бичиг нь коммунизмаас нээлттэй нийгэмд шилжих үед хэзээ нэгэн цагт хойд Солонгост үнэт туршлага, хосгүй сургамж болно.

**Abstracts:** The relations between the two countries has developed positively in most of the period of history. The relation between the two countries was hindered not by themselves but in fact by the changes of international relations, war and ideology. The relation between the two countries was conceived not by their aspiration but by the outside conditions. It seems that Mongolians have had a stable, warm, friendly and amiable images of Koreans.

Mongolia have to learn more from the South Korean experience while we must share our last 15 years experience with North Korea. The unity of Korea and it's flourishing will be very significant to Mongolia and also be very probable solving the issue of integration of North East Asia. The study of Korea-Mongolian relations at a new level with up-to-date research and information is considered an urgent need.

### Ном зүй

1. Ian Forbes, Steve Smith (eds.) "Politics and Human Nature", Frances Pinter, 1983. William Bloom, "Personal Identity, National Identity and International Relations", Cambridge University Press, 1990.
2. 13-р зуунаас өмнөх үеийн харилцааны талаар дурдсан зарим түүхчдийн бүтээлээс дурдвал, Х. Пэрлээ "Хятан нар, тэдний монголчуудтай холбогдох нь" УБ. 1959, Г. Сүхбаатар "Монголчуудын эртний өвөг, Хүн(нү) улсын түүх" УБ. 1980. "Сяньби нарын угсаа гарал, соёл, аж ахуй, нийгмийн байгуулалт" УБ, 1971. "Монгол Нирун улс" УБ. 1992. Ч. Далай "Монгол солонгосын эртний түүхэн харилцаа" УБ. 1998. Б. Сумъяабаатар "Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд" УБ, 1975.
3. Энэ эшлэлийг Ц. Дамдинсүрэн гуайн хөрвүүлсэн "МНТ"-ны орчуулгын 1990 онд хэвлэгдсэн 4 дэх хэвлэлээс авав. Харин уг хятад эхийнх нь монгол хөрвүүлэгт: "Урида Жүрчид Солангас-тур аялагсан Жалайрдай хорчийн гэжигэ Исүдэр хорчийг аялуулба. Танма суутугай хэмээн зарлиг болба." гэсэн буй. Монголын нууц товчоо. Галиглан хөрвүүлсэн Т. Дашцэдэн. Corpus Scriptorum Mongolorum. Tomus XXI, Fasciculus I. УБ.1985. 206-р талд. Мөн Японы монголч эрдэмтэн Shiratori Kurakichi-ийн 1942 онд Токиод хэвлүүлсэн эх болон галигийн 2-р дэвтрийн 28а-д мөн адил хөрвүүлсэн байна. (Shiratori Kurakichi, The Toyo Bunko Publications, Series C, Volumes VIII, Tokyo. 1942). Мөн Р. Чүлтэмсүрэн "Монголын уран зохиол дахь Солонгосын холбогдолтой нэгэн домгийн тухайд" Mongolian Studies, The Korean Association for Mongol Studies, 1995, дугаар N3, 241-248-р талаас үзнэ үү..
4. "Лу. Алтан товч"-д "Хулан хатны орд нь Солонгосын Барс орд...Есөн өнгө бүлэг улс нь ...Гууль улс хөх буюу. Суут Богд Чингис хаан таван их улсыг эрхэндээ оруулав гээд нэгийг нь дорно Солонгос улс" гэсэн байна. Лувсанданзан. "Алтан товч" (Хэвлэлд бэлтгэсэн Ц. Шагдар. УБ. 1990.) болон Лувсанданзан "Алтан товчи" (перевод с монгольского, комментария и приложения Н. П. Шастиной.) Москва, 1973. зэрэг эхүүдээс тодруулан үзнэ үү.
5. Б. Сумъяабаатар, "XIII-XIV зууны монгол-солонгос харилцааны бичгүүд", тэргүүн дэвтэр. УБ. 1978.
6. "Корё-са", Ионсейгийн их сургуулийн хэвлэл, 1955. Жон Ён сук, "Корё шидэ хүби" (Корёгийн үеийн хатад) Сөүл, 1992. Г.Эрдэнэчимэг, "Хутагбэх хатны улс төрийн байр суурь", Монгол солонгосын хамтарсан II эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, УБ, 2001.03.24, 189-200-р талд.
7. Ж.Баттөр. "Хан улсын түүх хэмээх нэгэн эх бичгийн судалгаа" УБ. 1998.
8. Г.Дэлэг. "Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл", УБ. 1965.

"Монголын Үнэн сонин", эмхтгэн тайлбарласан Д. Даш, УБ, 1971. УТТА-ийн тогтмол хэвлэлийн фонд.

Сурах бичиг: Эрдэнэбат. "Ази тив" Ардыг Гэгээрүүлэх Яам, 1928.

9. Ж. Баттөр, "XX зууны монгол-солонгосын харилцаа" Тэргүүн дэвтэр. УБ, 2000.

10. Мөн ном.

11. Мөн ном.

12. Ж. Баттөр, "XX зууны монгол-солонгосын харилцааны түүх" дэд дэвтэр, УБ, 2004.70-85-р тал.

13. УТТА, "Солонгос сургуулийн архивийн фондын баримтын данс" (1952-1959), Ф342-1-46.

14. Д. Ёндон, Я. Намсрай, З. Соль. "БНМАУ-ын хөгжилд гадаад эдийн засгийн харилцааны роль" УБ. 1980. 98-99-р талд.

15. И Анна (Улаанбаатар коллеж)"Монгол-есо-ый хангүг-о кю-юг-ый гуа-жье" (Монгол дахь солонгос хэлний боловсролын зорилт)"The 4<sup>th</sup> Overseas Workshop for Korean Language Educators, The International Association for Korean Language Education" Ulaanbaatar, 2004. 01.18. p-44.

16. В. Ноговнуам. (МУИС, ГХСС, ССТ) "Монгол-есо-ый хангүг-о кю-юг хёньхуан" (Монгол дахь солонгос хэлний сургалтын енөөгийн байдал) мөн тэнд. 35-р талаас үзнэ үү.

17. "Монгол улсын Үндэсний Статистикийн газар"-аас гаргасан "Монгол улс зах зээлд" статистикийн эмхтгэл, УБ. 2004. 37-38-р талд.

18. Баабар, "Зүүн хойд Ази ба Монгол". Тус өгүүлэл нэлээд хэд хэдэн удаа хэвлэгдсэн. Тухайлбал, "Шинэ эрин" сэтгүүлийн 2004 оны 12-р сарын дугаарын 30-31-р талуудаас үзэж болно. Бүрэн эхээр нь baabar.net буюу зохиогчийн вэбсайтаас харна уу.

19. Энэ талаар нэлээд их материал гарсан. Тухайлбал, "UN Document a/55/530-S/2000/1052 of 27 October, 2000", "UN Document A/57/59 of 20 March 2002", Andrew Mach, "A Northeast Asia Nuclear-Free Zone: Problems and Prospects" (in Nuclear Policies in Northeast Asia) 1990. Xia Liping. "Nuclear-weapon-free zones: Lessons for non-proliferation in Northeast Asia" 2001. Монголын судлаачдаас дипломатч Ж. Энхсайхан "Nuclear Security Issues in the East Asian Region: Challenges and Opportunities" МУИС-ийн ОУХС-ийн "Олон улсын харилцаа" (World Affairs) сэтгүүлийн 2003, №2, 231(08), 125-140-р талд.